



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХАРХОРИН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ХАЛДВАРТЫН ТАСГИЙН АЛБАН
ХЭРЭГЦЭЭНД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРТ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт
гэрээний нэр:

Өвөрхангай аймгийн Хархорин сумын
Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн албан
хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх

Батлагдсан төсөв: 20.000.000 төгрөг (Хорин сая төгрөг)

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хархорин сумын Засаг Даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Өвөрхангай аймаг Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт шаардлагатай байгаа эмнэлгийн хэрэгслийн жагсаалт” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000 /тавин мянга/ төгрөгийг** цахим систем ашиглан төлнө.

Үнийн саналыг **[2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 11:00 цаг]-аас өмнө [Өвөрхангай аймгийн Хархорин сумын, Ганган-Орхон баг, Орхон хороолол 20 тоот (tender.gov.mn)]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 06 дугаар сарын 09]-ны өдрийн [11:30]¹-т** ЗДТГазрын 2 давхар 208 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг даргын Тамгын газар
2 давхар 208 тоот өрөө, утас : 92066596, 99814699
tender.gov.mn-цахим систем**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүр**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- 4. дэл**

(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл
- 5. Тогтмол үнэ**

5.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 6. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

6.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

6.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 7. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

7.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 8. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

8.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

8.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

8.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно






**9. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

9.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.







Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн /1/ Аж ахуй нэгж бол 2019 оны жилийн санхүүгийн тайлан - Сүүлийн /1/ туршлагын мэдээлэл / гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар - Сүүлийн 1 /2019 оны/ борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 60%-аас багагүй байх - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 60%-аас багагүй байх - Бусад нэмэлт шаардлага - Харьяа татварын хэлтэс, нийгмийн даатгалын газраас өр, төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар наториотаар гэрчлүүлсэн байна. - Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх
ТӨӨЗ 2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: tender.gov.mn</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Байгууллагын хаяг: [Ганган-Орхон баг Орхон хороолол 20 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 208 тоот</p> <p>Огноо: 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.1	<p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: /багцгүй/</p>

Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт
шаардлагатай байгаа эмнэлгийн хэрэгслийн жагсаалт

№	Хэрэгсэлийн нэрс	Тоо ширхэг	Зураг	Техник үзүүлэлт
1	Өвчтөний ор	10		Хэмжээ : 2130*970*500мм Арын өргөх хэсэг 0°-75° Хүнд өвчтөн хэвтэхэд тохиромжтой, механик олон үйлдэлтэй байх
2	Орны дэрэгдэх шүүгээ	10		Хэмжээ : 440*9460*775мм 1 шургуулга, 1 тасалгаатай өвчтөн өөрт хэрэгтэй зүйлсээ хийдэг, төмөр болон хуванцар шүүгээ
3	Аналог жин, өндөр хэмжигч	5		150кг даацтай байх
4	Пульс-оксиметр	1		Хүчдэл: DC 2.6-3.6В Гүйдэл: <30aM SpO ₂ хэмжээний хязгаар: 0%-100% Зүрхний цохилтын хэмжих хязгаар: 30bpm-250bpm Нярай, хүүхэд болон том хүнд хэрэглэдэг, түргэн уншдаг байх
5	Эмийн хөргөгч	2		Хэмжээ : 250/310/588/1000л Температурын хязгаар 2-8°C Температурын нарийвчлал 0,1°C Эм, тариа хадгалах зориулалтын шилэн нүүртэй байх

6	Дуслын автомат шахуурга	1		Хэмжээ: 100*190*250мм 1-1000мл/шугаман /престатик/ TFT 4.3 inch LCD дэлэгцтэй, хэмжээ, хугацааг заадаг байх
7	Тариурын автомат шахуурга	1		Хэмжээ: 220*130*108мм TFT 4.3 inch LCD дэлэгцтэй, хэмжээ, хугацааг заадаг байх
8	Хүчил төрөгч өтгөрүүлэгч	1		5л/мин өгдөг, Гаралтын хүчилтөрөгч 93+/-3% дугуйтай, дуу чимээ багатай байх
9	Зөөврийн хүчил төрөгч өтгөрүүлэгч	1		5л/мин өгдөг, Гаралтын хүчилтөрөгч 93+/-3% дугуйтай, дуу чимээ багатай байх Автомашинны тамхины асаагуур болон 220В-т залгаж хэрэглэдэг байх
10	Соруулгын аппарат	1		Сорох даралт : /хамгийн их утга/ ≥ 90 кРА Шингэн сорох савны хэмжээ: 2,5л /2 ширхэг/ багтаамжтай, Тасралтгүй ажиллах Хугацаа: 30 мин
11	Автомат даралтын аппарат	1		Дундаж буглаг ороох хэмжээтэй, 220в-д ажилладаг мөн цэнэглэж ашигладаг байх
12	Яаралтай тусламжийн шүүгээ	2		Хэмжээ: 710*480*950мм Дефибрилляторын тавиуртай байх, дугуйтай, олон шургуулагатай байх

13	Бохрын даавуун тэргэнцэр	7		60л-н багтаамжтай, зэвэрдэггүй ган хүрээтэй, ус нэвтрүүлдэггүй ууттай, дугуйтай байх
14	Сувилагчийн тэргэнцэр	7		Хэмжээ: 625*475*920мм Зэвэрдэггүй ган хүрээтэй, хуванцар давцантай байх
15	Хаалт	4		Хэмжээ : 300*1820мм Дугуйтай, хөшиг нь салгаж угаадаг байх
16	Хяналтын монитор	2		12,1 inch дэлгэцтэй, ECG, SpO ₂ , NIBP, pulse rate 6-12 сувгаар зүрхний бичлэг хийдэг, үзүүлэлтүүдийг хадгалдаг байх
17	Дуудлагын хонх	8		10ш дуудлагын хонхтой байх
18	Яаралтай тусламжийн цүнх	3		20 л багтаамжтай, Яаралтай тусламжинд хэрэглэгдэх бат бөх материалаар хийгдсэн хоосон цүнх

19	Үзлэгийн ор	10		Хэмжээ: 1830*560*800мм Зэвэрдэггүй ган хүрээ, зөөлөн хөвөн доторлогоотой байх
20	Өвчтөн зөөвөрлөх дамнуурга	2		Хэмжээ: 2250*550*160мм Хатуу, нугардаггүй, өвчтөнд тухтай байх

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээг үй-гээс | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

**гэрээг
цуцлах**

- 11.Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ____ -наас _____ оны ___ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

